



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/307

Улаанбаатар хот

### Баянзүрх дүүргийн 311 дүгээр цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дээрит” олон улсын байгууллагаас хандивласан нийт 12,516,000.00 (арван хоёр сая таван зуун арван зургаан мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн 311 дүгээр цэцэрлэг (Н.Нандин-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 311 дүгээр цэцэрлэг (Н.Нандин-Эрдэнэ) үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
 2024 оны 08 дугаар сарын 26 -ны өдрийн  
 АХФ дугаар тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 311 дүгээр цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэрээр	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ		
1	Хөргөгч	MI	500 литр	2023	сайн	ш	1	2,888,000.0	2,888,000.0	"Дээрит" Олон улсын байгууллага	
2	Шарах шүүгээ	ZH-ТТ-44	4 ширэмтэй	2023	сайн	ш	1	3,600,000.0	3,600,000.0		
3	Ариутгагч	M-D2	500 ш аяга угаах	2023	сайн	ш	2	930,000.0	1,860,000.0		
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>								<b>8,348,000.0</b>			
4	Ширээ	Хятад	никель тавцантай төмөр хөлтэй	2023	сайн	ш	4	390,000.0	1,560,000.0	Төсөл хөтөлбөр	
5	Тавиур	Хятад	120x50	2023	сайн	ш	2	358,000.0	716,000.0		
6	Тавиур	Хятад	150x50	2023	шинэ	ш	2	388,000.0	776,000.0		
7	Тавиур	Хятад	180x50	2023	сайн	ш	2	558,000.0	1,116,000.0		
<b>Тавилга, эд хогшлын дүн</b>								<b>10</b>			
<b>Нийт бүртгэх хөрөнгийн дүн</b>								<b>14</b>	<b>4,168,000.0</b>	<b>12,516,000.0</b>	